МЭДЭЭ · 2023 оны 12-р сарын 8

ЦАГДАН ХОРИХ 461 ДҮГЭЭР ХААЛТТАЙ АНГИД АЖИЛЛАЖ, АНХААРАХ АСУУДЛААР ҮҮРЭГ ӨГЛӨӨ



Улсын ерөнхий прокурорын газар, Хүний Эрхийн Үндэсний Комисс хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид ажиллаж байгаа талаар өмнө нь мэдээлсэн. /Энд дарж үзнэ үү/

Тус ажлын хүрээнд тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн, дүнг Нийслэлийн прокурорын газар, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр танилцуулж, анхаарах асуудлаар үүрэг өглөө.

Тодруулбал, цагдан хоригдож байгаа хүмүүсийн ахуй нөхцөл, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буй байдлыг биечлэн танилцахад хүний эрхийн болоод холбогдох хууль тогтоомжийн зөрчил гараагүй боловч албан хэрэг хөтлөлттэй холбоотой анхаарах асуудлууд илэрсэн байна.

Тухайлбал, баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд баримт, материалын бүрдлийг хангаагүй, сэтгэл зүйн дүгнэлт, тодорхойлолт, хувийн хэргийн шилжилт, хөдөлгөөнийг дутуу хийсэн зэрэг зөрчил тогтоогджээ. Тиймээс энэ талаар

анхааруулж, хүний эрхийг дээдэлж, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үүрэг болгон, биелэлттэй эргэн танилцахаар болсон байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1373